

Гөөнөгийн Лхүндэв[✉], Батмөнхийн Цогтбаатар¹, Насан-Очирын Эрдэнэ-Очир¹,
Эрдэнэ-Очирын Амарболд¹, Такаши Осава²

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн.

Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,

Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

²Осака Их сургуулийн Хэл, Соёлын сургууль, Түрэг судлалын салбар.

8-1-1 Аоматани-Хигаши, Минох хот, Осака 562-8558, Япон

“Донгойн Ширээ”-ний дурсгал дахь тамганы бүтэц ба дүрслэлийн судалгаа

Хураангуй: Монгол орны нутаг дэвсгэр дэх чулуун өв соёлын нэг нь байгалийн хад чулуу болон зориуд засаж бэлдсэн хөшөө чулуунд сийлж үлдээсэн тамга тэмдгийн дурсгал юм. Тамга тэмдгийн дурсгал нь дангаар байхаас гадна элдэв сүг зураг болон бичиг үсгийн хамт дүрслэгдсэн байх нь олонтоо ажээ. Энэ төрлийн дурсгалууд нь харилцан адилгүй он цагт хамаарах бөгөөд тухайн үеийн овог аймаг, нийгмийн бүтэц зохион байгуулалт, газар нутаг, хэл соёл, угсаатан хийгээд бэлгэдэл зүйн талаарх үнэт мэдээллийг хадгалсан байдаг. Ийм дурсгалын нэг бол Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг “Донгойн Ширээ” хэмээх газраас илэрсэн олон хөшөөт цогцолбор дурсгал дахь тамганы дүрслэл юм. Энэ дурсгалын хөшөө чулуунд сийлсэн тамга, түүний төрөл, дүрслэл, хоорондын харьцаа болон агуулга зэрэг нь судалгааны чухал ач холбогдолтой хэсэг юм. Тус өгүүлэлд “Донгойн Ширээ”-ний дурсгал дахь тамганы дүрс, тэдгээрийн байрлал, харьцаа, хэлбэр болон агуулга, зохиомжийн онцлогийг нарийвчлан шинжилж, археологийн болон түүхэн-харьцуулалт, дүрслэл зүйн үүднээс тайлбарлахыг зорьсон болно. Мөн эртний тамга тэмдгийн уламжлал, утга агуулга, бэлгэдлийг харьцуулан үзэх замаар соёлын онцлог, утга зүйн үүргийг тодорхойлохыг зорив.

Түлхүүр үг: хөшөө чулуу, дүрс, сийлмэл, овог аймаг, тамга, янгир, онги

Lkhundev Guunii[✉], Tsogtbaatar Batmunkh¹, Erdene-Ochir Nasan-Ochir¹,
Amarbold Erdene-Ochir¹, Osawa Takashi²

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences Building-1,
Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia.

²Osaka University, Graduate School of Language and Culture
Head of the school of Turkic Studies. Minoh-city, Osaka 562-8558, Japan

A study of the structure and iconography of tamgas in the “Dongoin Shiree” monument

Abstract. Among the diverse manifestations of Mongolia’s stone heritage are tamga engravings found on both natural rock surfaces and intentionally shaped stone monuments. These tamga inscriptions occur either independently or in conjunction with petroglyphs and written scripts. Such monuments belong to different chronological periods and preserve invaluable information regarding the clan and tribal systems, sociopolitical organization, territorial demarcation, linguistic and cultural development, ethnic identity, and symbolic beliefs of the respective eras. The “Dongoin Shiree” complex, located within the territory of Tüvshinshiree soum, Sükhbaatar province, represents one such significant site that contains an assemblage of stone monuments bearing engraved tamgas. The variety, composition, proportional relationships, and semantic content of these tamgas constitute important material for historical and archaeological inquiry. This article aims to conduct a detailed analysis of the tamga motifs found at the “Dongoin Shiree” monument, focusing on their placement, proportions, forms, meanings, and compositional characteristics. Furthermore, it seeks to interpret these features from archaeological, historical-comparative, and iconographic perspectives. By comparatively examining the traditions, meanings, and symbolism of ancient tamga signs, the study also aims to identify their cultural characteristics and semantic functions.

Keywords: stone monuments, images, rock carvings, clans and tribes, tamga (tribal marks), Ibex, Onggi

Удиртгал

Судлагдсан байдал: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг дахь “Донгойн Ширээ” хэмээх газарт буй нэгэн нууцлаг дурсгалыг анх 2010 онд “Дорнод Монгол” төслийн судлаачид илрүүлэн олсон (Түмэн нар 2010, 169) ба 2013 (Мөнхтулга нар 2014), 2015-2017 онуудад малтан судалсан юм (Цогтбаатар нар 2016, 69-163; Цогтбаатар нар 2017, 3-86; Цогтбаатар нар 2017, 3-152). Малтлага судалгааны үр дүнд уг дурсгалыг эртний Түрэгийн хожуу хаант улсын үе (654-715AD; 680-779AD 95,4%-д бүтээн босгосон болохыг үнэмлэхүй он цаг тогтоох аргаар тогтоосон ба хожим хэд хэдэн удаа тоногдож сүйтгэгдсэн байна. Хөшөөний голлох бичээсийн үсэг зүй, хэл зүйн онцлог, тамгын хэлбэр, чулуун хавтангийн дүрслэл зэргээр нь НТ 735-745 оны үед (Мөнхтулга, Оосава 2015, 53-54) холбогдоно хэмээн судлаачид тэмдэглэсэн байдаг.

Уг дурсгалыг малтан судалсан тухай болон хөшөө чулууны бичээс, тамга тэмдгийн талаарх судалгааг дангаар болон нэгтгэсэн байдлаар өмнө нь тайлан, илтгэл, товхимол хэлбэрээр хэд хэдэн удаа гаргаж байв. Харин тамга тэмдгийн дурсгалыг тухайлсан нэг хөшөө эсвэл нийт хөшөөнд дүрслэгдсэн байдлаар, ингэхдээ зарим тохиолдолд тодорхой бус дүрсийг оруулж нийт тамганы тоог тойм байдлаар танилцуулж байв.

Энэ удаа, бид хөшөө чулуунд бичээс сийлэхээс өмнө болон дээрээс нь давхарлан сийлсэн тамганы дүрсийг бус харин нүдэнд харагдаж гарт мэдрэгдэх тамганы цуглуулгыг нэгтгэн дүн шинжилгээ хийхийг зорьсон юм.

Судалгааны хамрах хүрээ: Тус дурсгалт газраас зүүн болон урд талдаа шулуун, баруун болон хойд талдаа хагас дугуй хэлбэртэй тойрог байдлаар босгосон 14 гэрэлт хөшөө илэрсэн. Хөшөө бүрийг хугалж эвдэн сүйтгэжээ. Харин хөшөөний суурь нь анх босгосон газартаа байсан тул түүнд тулгуурлан уг дурсгалын бүтэц, зохион байгуулалтыг бүрэн тодруулж чадсан билээ. Нийт 14 хөшөөтэй ба нэг (№14) нь маш олон хугарч бутарсан, нөгөө (№7) нь барзгар гадаргуутай тул тамга дүрсэлсэн эсэх нь мэдэгдэхгүй байна. Үлдсэн 12 хөшөөнд харилцан адилгүй тоотой тамга дүрсэлжээ. Нийт тамганы тоо 100 илүү гарах нь лавтай бөгөөд харагдах байдлаар нь дараах гурван хэлбэрт хувааж болохоор байна.

Нэгдүгээрт, тамганы дээрээс бичээс *давхарлаж* сийлсэн (зөвхөн 6-р хөшөөний баруун дээд талд 30 гаруй тамга байгаа хэмээн үздэг)

Хоёрдугаарт, элэгдэж бүдгэрсэн буюу *маш бүдэг* мэдэгдэх тамга

Гуравдугаарт, маш тод буюу *тодорхой* харагдах тамга хэмээн хуваав.

Хүснэгт-1.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Хэлбэр тодорхойгүй тамга (шулуун зураас)	1	нүүр (дээд)	дан	10?x1,0	—	
Чагттай саран тамга	2	нүүр (дээд)	дан	41x18	卐	
Чагт тамга	3	нүүр (дунд)	хосолсон	6x7	卐	
Сэрээ (сам) тамга	4	нүүр (дунд)	хосолсон	7x8	卐	
Гурвалжин тамга	5	нүүр (дунд)	дан	19x20	△	
Алхтай дөрвөлжин тамга	6	нүүр (дунд)	хосолсон	13x11	卐	
Зуузай тамга <i>Үүнийг могой тамга хэмээн нэрлэх явдал ч бий.</i>	7	нүүр (дунд)	хосолсон	59x0,5	卐	
Хайруул тамга (гашуу)	8	нүүр (дунд)	хосолсон	5,5x0,8	卐	
Нүдтэй, сүүлтэй онги тамга	9	нүүр (дунд)	хосолсон	12,5x7	卐	
Ац тамга (хөндлөн)	10	нүүр (дунд)	дан	12x19	卐	
Ацтай сэрээ тамга	11	нүүр (дунд)	дан	10x10	卐	
Сүүлтэй онги бүхий гурвалжин тамга	12	нүүр (доод)	дан	23,6x14,5	卐	

Хүснэгт-2.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Тушаатай, босоо дан саран тамга	1	нүүр (дунд)	дан	10x14		
Иштэй дөрвөлжин бүхий гурвалжин тамга	2	нүүр (дунд)	дан	20x12		
Хөлтэй алх бүхий гурвалжин тамга	3	нүүр (дунд)	дан	19x10		

Эдгээрээс маш тод ангилалд хамаарах 73 тамгыг судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн болгон авч үзэв. Түүнчлэн Монгол нутгаас илэрч олдсон ойролцоо цаг хугацаанд хамаарах ижил төстэй тамга тэмдэг болон тамганы талаар судалгаа шинжилгээ хийсэн судлаачдын зохиол бүтээлээс цухас боловч ашигласан болно.

Судалгааны арга зүй

Судалгааны үндсэн эх сурвалж нь “Донгойн ширээ” хэмээх газраас олдсон эртний Түрэгийн үед холбогдох цогцолбор дурсгал дахь тамга тэмдгийн дүрслэл болно. Уг дурсгалт газрын малтлага судалгааны үр дүнд илрүүлсэн хөшөө чулуун дээрх тамганы дүрсийн гэрэл зураг, хэв

хуулгыг цаасан хэлбэрээр авч баримтжуулсан юм. Үүнээс гадна хээрийн судалгааны уламжлалт арга зүйн дагуу хөшөө чулууны тамга тус бүрийн тодорхойлолтыг үйлдэхдээ хэмжих багаж хэрэгслийг ашигласан болно. Мөн тамганы дүрслэлийн болон бүтэц судлалын арга (харьцуулалт, дүрслэл зүй, утга судлал, археометр г.м)-ыг тус тус хэрэглэв.

Тамганы бүтцийн шинжилгээ

Тамганы бүтэц ба дүрслэл: Тамганы бүтэц, дүрслэл, байрлалын дан ба хосолсон эсэх зэргийг дээрээс доош үргэлжлэх байдлаар тамгатай хөшөө тус бүрээр гаргав. Хүснэгт тус бүр дэх хөшөө чулуу, тамганы байрлал хэсэг дэх баруун талын

Хүснэгт-3.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Тушаатай, босоо дан саран тамга	1	нүүр (дунд)	дан	15x30		
Нүдтэй онги тамга	2	нүүр (дунд)	дан	Голч-20		
Хайчин тамга	3	нүүр (дунд)	дан	34x30		
Эвэртэй угалз (дэгээ) тамга <i>Энэ тамгыг эвэртэй, задгай онгин тамга, Торгуудын хахууль (дэгээ), Захчины угалз тамга гэж нэрлэх нь бий.</i>	4	нүүр (дунд)	дан	10x19		

тоо нь дан, зүүн талын тоо нь хосолсон тамга тус бүрийг илэрхийлнэ.

Нэгдүгээр хөшөө. Нимгэн хавтгай хэлбэртэй, 332 см урт, 58 см өргөн, 33 см зузаан ажээ. Хөшөө нь суурь хэсгээрээ нэг, орой хэсгээрээ хоёр хугарсан. Нүүрэн талдаа 12 тамгатай (хүснэгт-1).

Хөшөө чулууны оройн хэсэг хугарах явцад хамгийн дээр байрлах гол тамга гэмтэж дүрслэл нь бүрэн танигдахааргүй болжээ. Зуузай тамга (7-р)-ны зүүн талд гурван тамга дүрсэлжээ. Эдгээрээс дээр нь байрлах алхтай дөрвөлжин тамга (6-р)-ыг зуузай тамгатай хосолсон хэмээн үзэв. Дээрх тамгануудаас нүдтэй, сүүлтэй онги (9-р) тамгыг бусдаас илүү гүн ухаж сийлсэн нь сонирхол татна.

Хоёрдугаар хөшөө. Гонзгой бөөрөнхий хэлбэртэй, 373 см урт, 45 см өргөн, 30 см зузаан

ажээ. Хөшөө чулуу нь голоороо хоёр хугарсан. Нүүрэн талын дунд хэсгийн хүнхэр тэгш гадаргууд дээрээс доош цувуулан дүрсэлсэн 3 тамгатай (хүснэгт-2). Хамгийн доор байрлах тамга хөшөө хугарах явцад дундуураа хугарч гэмтсэн боловч дүрслэл нь тодорхой мэдэгдэнэ.

Гуравдугаар хөшөө. Гонзгой хэлбэртэй, 472 см урт, 51 см өргөн, 30 см зузаан ажээ. Хөшөө нь голоороо гурав хугарсан. Нүүрэн талын дунд хэсэгтээ дээрээс доош цувуулан дүрсэлсэн 4 тамгатай (хүснэгт-3).

Дөрөвдүгээр хөшөө. Нимгэн хавтгай хэлбэртэй, 425 см урт, 54-56 см өргөн, 15-17 см зузаан ажээ. Хөшөө чулуу нь голоороо дөрөв хугарсан. Нүүрэн талын дунд хэсэгт 2, ар талын дунд хэсэгтээ 1 тамгатай (хүснэгт-4).

Хүснэгт-4.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Урт сөртөн бүхий иштэй сэрээ тамга	1	нүүр (дунд)	дан	17x13		
Дэгээ тамга (буруу харсан)	2	нүүр (дунд)	дан	17x6		
Хямсаа тамга	3	ар (дунд)	дан	24x11		

Тавдугаар хөшөө. Гонзгой, бөөрөнхий хэлбэртэй, 486 см урт, 40-47 см өргөн, 32-36 см зузаан ажээ. Хөшөө чулуу нь дээд болон суурь

хэсгээрээ хоёр хугарсан. Нүүрэн талын дунд хэсэгтээ дээрээс доош цувуулан дүрсэлсэн 4 тамгатай (хүснэгт-5). Уг хөшөө нь руни бичээстэй.

Хүснэгт-5.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Тушаатай, босоо дан саран тамга	1	нүүр (дунд)	дан	7,5x13		
Янгир тамга	2	нүүр (дунд)	хосолсон	27x14		
Голоороо хөндөлтэй, иштэй онги тамга	3	нүүр (дунд)	хосолсон	16x9,5		
Энэ тамгыг хэлтэй, дугуй хүрээтэй мухар арал тамга гэж нэрлэх нь ч бий.						
Янгир тамга	4	нүүр (дунд)	дан	17x12		

Голоороо хөндөлтэй, иштэй онги тамгатай хосолж байрлах янгир тамганы толгойг сүйх

хэлбэртэй, хэвлий дор хагас дугуй бүхий нэмэлттэй дүрсэлжээ.

Зургаадугаар хөшөө. Дөрвөн талт гонзгой хэлбэртэй, 440 см урт, 52 см өргөн, 32 см зузаан ажээ. Хөшөө нь суурь хэсгээрээ хугарсан. Нүүрэн талдаа 13, баруун болон ар талдаа тус бүр 1 тамгатай (хүснэгт-6). Уг хөшөө нь руни бичээстэй. Хөшөөний нүүрэн талын руни бичээсийн дээр нэг

янгир тамгыг бусад 12 тамгыг бичээсийн баруун талд дээрээс доош, нэг янгир тамгыг баруун талын дунд хэсэгт руни бичээсийн дунд, нэг дугуй тамгыг дангаар нь ар талын доод хэсэгт тус тус дүрсэлжээ.

Хүснэгт-6.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Янгир тамга	1	нүүр (дээд)	дан	19x13		
Иштэй онгитой, гурвалжин тамга	2	нүүр (дунд)	дан	17,8x12		
Хэвтээ дан сартай онги тамга	3	нүүр (дунд)	дан	17x15		
Хэвтээ дан саран тамга	4	нүүр (дунд)	дан	0,4x14,5		
Онги тамга	5	нүүр (дунд)	дан	Голч-9		
Нүдтэй онги тамга	6	нүүр (дунд)	хосолсон	Голч-15,5		
Онги тамга	7	нүүр (дунд)	хосолсон	Голч-14,5		
Дөрвөлжин тамга	8	нүүр (дунд)	хосолсон	11x7,5		
Онги тамга	9	нүүр (дунд)	хосолсон	Голч-11		
Голоороо хөндөлтэй, сүүлтэй онги тамга	10	нүүр (дунд)	дан	6,3x11,2		
Хос хайруул тамга (ташуу)	11	нүүр (дунд)	дан	4,5x11,5		
Онги тамга	12	нүүр (дунд)	дан	Голч-11,5		
Алхтай гурвалжин тамга	13	нүүр (дунд)	дан	14x10,5		
Онги тамга	14	ар (доод)	дан	Голч-12		
Янгир тамга	15	баруун (дунд)	дан	21x12		

Наймдугаар хөшөө. Гонзгой, хавтгай хэлбэртэй, 432 см урт, 53 см өргөн, 30 см зузаан ажээ. Хөшөө нь голоороо хоёр хугарсан. Нүүрэн талдаа 8, ар талдаа 3 тамгатай (хүснэгт-7). Уг хөшөө нь нүүрэн талдаа хар бэхээр бичсэн хятан бичээстэй.

Уг хөшөөний янгир тамганы дүрслэл болон хэмжээ нь харилцан адилгүй. Хоёр дугаар бүхий янгир тамгыг бусад тамганаас илүү гүн ухаж сийлжээ.

Есдүгээр хөшөө. Гонзгой, хавтгай хэлбэртэй, 473 см урт, 49-55 см өргөн, 27 см зузаан ажээ. Хөшөө нь голоороо хугарсан. Нүүрэн талдаа 4 тамгатай (хүснэгт-8).

Аравдугаар хөшөө. Гонзгой, хавтгай хэлбэртэй, 445 см урт, 46-51 см өргөн, 12-27 см зузаан ажээ.

Хөшөө чулуу нь голоороо дөрөв хугарсан. Нүүрэн талдаа 7 тамгатай (хүснэгт-9).

Арван нэгдүгээр хөшөө. Гонзгой, хавтгай хэлбэртэй, 426 см урт, 48-56 см өргөн, 18-22 см зузаан ажээ. Хөшөө нь суурь хэсгээрээ нэг, орой хэсгээрээ хоёр хугарсан. Ар талдаа 5 тамгатай (хүснэгт-10).

Арван хоёрдугаар хөшөө. Гонзгой, бөөрөнхий хэлбэртэй, 443 см урт, 47-53 см өргөн, 30-36 см зузаан ажээ. Хөшөө чулуу нь суурь болон дунд хэсгээрээ хугарсан. Нүүрэн талын доод хэсэгтээ 1 тамгатай (хүснэгт-11).


Хүснэгт-7.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Онги тамга	1	нүүр (дунд)	дан	голч-0,8		
Янгир тамга	2	нүүр (дунд)	дан	18x12		
Янгир тамга	3	нүүр (дунд)	дан	30x20		
Янгир тамга	4	нүүр (дунд)	дан	21x15		
Янгир тамга	5	нүүр (дунд)	дан	28x19		
Янгир тамга	6	нүүр (дунд)	дан	20x15		
Нуман тамга	7	нүүр (дунд)	дан	16x3,5		
Янгир тамга	8	нүүр (дунд)	дан	0,9x11,5		
Янгир тамга	9	ар (дээд)	хосолсон	21x15		
Онги тамга	10	ар (дээд)	хосолсон	голч-0,9		
Онги тамга	11	ар (дээд)	дан	голч-0,8		


Хүснэгт-8.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Янгир тамга	1	нүүр (дунд)	дан	20x20		
Нүдтэй дөрвөлжин тамга	2	нүүр (дунд)	дан	7,5x6,3		
Янгир тамга	3	нүүр (дунд)	дан	30x21		
Дамар тамга	4	нүүр (дунд)	дан	22x11		

Хүснэгт-9.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Хос иштэй дөрвөлжин тамга	1	нүүр (дунд)	дан	23x11,2		
Янгир тамга	2	нүүр (дунд)	дан	24,5x21		
Чагттай дэгээ тамга	3	нүүр (дунд)	дан	34x26		
Иштэй дөрвөлжин тамга	4	нүүр (дунд)	хосолсон	9x18		
Дөрвөлжин тамга	5	нүүр (дунд)	хосолсон	0,6x0,5		
Хос иштэй дөрвөлжин тамга	6	нүүр (дунд)	хосолсон	24x19		
Онги тамга	7	нүүр (дунд)	хосолсон	голч-18		

Хүснэгт-10.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Дамар тамга	1	ар (дунд)	дан	25x10		
Янгир тамга	2	ар (дунд)	хосолсон	18x13		
Ац тамга	3	ар (дунд)	хосолсон	0,6x0,7		
Хайруул тамга	4	ар (дунд)	хосолсон	0,8x7		
Янгир тамга	5	ар (дунд)	дан	21x23		

Хүснэгт-11.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Нүдтэй, эвэртэй онги тамга	1	нүүр (доод)	дан	голч-10 эвэр-7		

Арван гуравдугаар хөшөө. Гонзгой, хавтгай хэлбэртэй, 421 см урт, 50-63 см өргөн, 20-24 см зузаан ажээ. Хөшөө чулуу нь олон удаа хугарсан, гадаргуу нь нэлээд элэгдсэн тул бусад хөшөөний

тамгыг бодвол дүрслэл нь нэлээд баларч бүдгэрчээ. Хөшөө нь ар талдаа 4 тамгатай (хүснэгт-12). Нүүрэн талдаа сийлмэл хятан бичээстэй.

Хүснэгт-12.

Тамганы бүтэц	Эгнээ, дугаар	Тал	Дан / Хосолсон	Хэмжээ (см)	Гар зураг	Хөшөө чулуу, тамганы байрлал
Иштэй дөрвөлжин тамга	1	ар (дээд)	дан	15x17		
Ац тамга	2	ар (дээд)	дан	-		
Гурвалжин тамга	3	ар (дээд)	дан	10x9		
Хэлбэр тодорхойгүй тамга (иштэй ? тамга)	4	ар (дээд)	дан	?		

Тамганы бүтцийн судалгааг хөшөө чулуу тус бүрээр авч үзэхэд нэг хөшөөнд хамгийн багадаа 1, дээд тал нь 15 тамгыг тус тус дүрсэлсэн байна. Нэг тамга дүрсэлсэн хөшөөний хувьд гол тамга хаана байрлах нь төдий л чухал биш байсан бололтой. Тухайлбал, ийм жишээ 12-р хөшөөнд тохиолдож байна. Харин олон тамгатай хөшөөний хувьд дээрээс доош үргэлжлэх зарчмаар хамгийн дээр байрлах нь гол тамга болох бөгөөд хөшөөний зөвхөн нүүр бус ар тал (дээд, дунд)-ыг ч чухалчилдаг байсан бололтой. Үүнийг 4, 8, 11, 13-р хөшөөний тамганы байрлалаас харж болохоор байна. Мөн руни бичээс бүхий 6-р

хөшөөний тамганы байрлал ч үүнийг давхар нотолно. Ийм жишээ Монгол нутаг дахь руни бичгийн их дурсгал бүхий гэрэлт хөшөөнд ч түгээмэл ажиглагддаг.

Тамганууд нь байрлалын хувьд ихэнх нь дан ажээ. Цөөн буюу 10 тохиолдолд л хосолсон байрлалтай дүрслэгдсэн байна. Тамганы хосолсон байдлыг нэгэн овгоос салбарласан эсхүл эрх мэдэл, байр суурийн хувьд ойролцоо овгууд хэмээн үзэх нь ч бий.

Нийт тамганы дотроос онги болон янгир тамгыг эс тооцвол нэг хөшөөнд олноор дүрсэлсэн нэг төрлийн тамга харьцангуй цөөн байна.

Энэ нь нэг хөшөөнд овог тус бүрийн тамга л дүрслэх тогтсон уламжлал байгааг илтгэнэ. Олон тоотой янгир тамганы хувьд бүгд тогтсон нэг хэв загвартай бус олон хэлбэр дүрстэй байгаа нь эртний Түрэгийн хаад язгууртны Ашина овог олон салбар салаалсан байдлыг илтгэх баримт байж болох юм. Онги тамганы хувьд ч хэлбэрийн хувьд бүгд ижил боловч хэмжээний хувьд харилцан адилгүй байх ажээ.

Олон янгир тамгатай 6-р хөшөөний дээд талд Хятаны хар бэхэн бичээс байгаа нь ихэд сонирхолтой ажээ. Он цагийн хувьд бичээс нь арай хожуу үед холбогдоно. Энэ нь зориудаар янгир тамганы дээд талд хожим бичсэн хэмээн таамаглахад хүргэж байна.

Тамганы дүрслэлийн шинжилгээ

Тамганы дүрслэл ба бүрэлдэхүүн хэсгүүд:
Тамганы дүрслэлийн шинжилгээг маш тод

харагдах 73 тамганы дүрслэлд тулгуурлан хийв. Эдгээрээс хоёр тамга нь хөшөө хугарах явцад гэмтэж дүрслэл нь бүрэн танигдахааргүй болжээ. Судалгаанд хамрагдсан тамгыг дүрслэлийн хувьд нэг дүрсээс бүрдэж байвал үндсэн, хоёр дүрсээс бүрдэж байвал үүсгэмэл гэж тамга судлалын арга зүйн дагуу хоёр ангилав. Үүсгэмэл тамгыг дотор нь дан (хоёр дүрсээс бүрдэх) болон давхар (гурав буюу түүнээс дээш) үүсгэмэл гэж хуваав (хүснэгт-13). Нийт тамга нь 16 төрөл дүрслэлд хамаарна.

Үүнээс гадна тамгыг хэлбэр дүрсээр нь амьтны дүрст тамга (янгир), геометрийн дүрст тамга (дугуй, дөрвөлжин, гурвалжин), багаж зэвсгийн дүрст тамга (хайч, хямсаа, дэгээ, сэрээ), огторгуйн дүрст тамга (саран, наран-дугуй, угалз), эд хэрэглэлийн дүрст тамга (дамар, нум, чагт) хэмээн ангилж болохоор байна.

Хүснэгт-13.

Нийт тамга - 73		Үндсэн тамга		Үүсгэмэл тамга			
				Дан үүсгэмэл		Давхар үүсгэмэл	
1.	Янгир	1.	Янгир	1.	Янгир	1.	Онги
2.	Онги	2.	Онги	2.	Онги	2.	Гурвалжин
3.	Дөрвөлжин	3.	Дөрвөлжин	3.	Дөрвөлжин	3.	Янгир
4.	Гурвалжин	4.	Гурвалжин	4.	Гурвалжин	4.	Сэрээ
5.	Саран	5.	Саран	5.	Саран		
6.	Сэрээ (сам)	6.	Сэрээ (сам)	6.	Сэрээ		
7.	Хайруул	7.	Хайруул	7.	Хайруул		
8.	Дамар	8.	Дамар	8.	Дэгээ		
9.	Ац (булан)	9.	Ац (булан)	9.	Угалз (дэгээ)		
10.	Дэгээ	10.	Дэгээ				
11.	Зуузай	11.	Зуузай				
12.	Хайчин	12.	Хайчин				
13.	Хямсаа	13.	Хямсаа				
14.	Нуман	14.	Нуман				
15.	Чагт	15.	Чагт				
16.	Угалз (дэгээ)						
17?	2 тамганы дүрс тодорхойгүй						
16 төрөл 71 тамга		37		25		9	

Тамганы байршил, харилцан хамаарал:
Малтлага судалгааны тайланд бүртгэж тэмдэглэснээр цогцолбор дурсгалын хамгийн баруун талын хөшөөг болзмол байдлаар нэгдүгээр хөшөө хэмээн үзэв. Уг хөшөөнөөс нар зөв эргэх зарчмаар дугаарлаж хөшөө чулуу тус бүрээр, аль талд нь хэдэн тамга дүрсэлсэн байдалд тулгуурлан байршлыг гаргасан юм. Ингэхэд, хөшөө чулууны нүүрэн талд 7 (хөшөө-1, 2, 3, 5, 9, 10, 12); нүүр болон ар талд 2 (хөшөө-4, 8); нүүр, баруун болон ар талд 1 (хөшөө-6); ар талд нь 2 (хөшөө-11, 13) удаа тус тус тамга сийлжээ. Хөшөө чулууны нүүрэн тал гэдэгт тойрог байдлаар босгосон

хөшөөний дотогш харсан талыг ойлгох ба улмаар зөв эргэх зарчмаар баруун, ар, зүүн тал гэсэн дарааллыг баримталсан болно.

Тамга сийлсэн байршил нь хөшөө чулуунд (орой буюу дээд, дунд, доод) илт ялгарах дараах байдалтай байна. Үүнд, хөшөө чулууны нүүрэн талын дээд хэсэгт 3, нүүрэн талын дунд хэсэгт 53, нүүрэн талын доод хэсэгт 2; баруун талын дунд хэсэгт 1; ар талын дээд хэсэгт 8, ар талын дунд хэсэгт 5, ар талын доод хэсэгт 1 тамга тус тус сийлсэн байна. Үүнийг тамганы дүрслэл тус бүрээр авч үзвэл доорх байдалтай байна (хүснэгт-14).

Хүснэгт-14.

№	Тамга байрлах тал	Тамга	Хөшөө чулуу болон тамганы дугаар
1	Нүүрэн талын дээд хэсэгт	Чагттай сар	1-2*
		Янгир	6-1
		Хэлбэр тодорхойгүй	1-1
2	Нүүрэн талын дунд хэсэгт	Чагт	1-3
		Сэрээ	1-4
		Гурвалжин	1-5
		Алхтай дөрвөлжин	1-6
		Зуузай	1-7
		Хайруул	1-8
		Нүдтэй, сүүлтэй онги	1-9
		Ац	1-10
		Ацтай сэрээ	1-11
		Тушаатай, босоо дан сар	2-1; 3-1; 5-1
		Иштэй, дөрвөлжин бүхий гурвалжин	2-2
		Хөлтэй алх бүхий гурвалжин	2-3
		Нүдтэй онги	3-2; 6-6;
		Хайч	3-3
		Эвэртэй угалз	3-4
		Урт сөртөн бүхий иштэй сэрээ	4-1
		Дэгээ	4-2
		Янгир	5-2; 5-4; 8-2; 8-3; 8-4; 8-5; 8-6; 8-8; 9-1; 9-3; 10-2
		Голоороо хөндөлтэй иштэй онги	5-3
		Иштэй онги бүхий гурвалжин	6-2
		Хэвтээ дан сартай онги	6-3
		Хэвтээ дан сар	6-4
		Онги	6-5; 6-7; 6-9; 6-12; 8-1; 10-7
		Дөрвөлжин	6-8; 10-5
		Голоороо хөндөлтэй сүүлтэй онги	6-10
		Хос хайруул	6-11
		Алхтай гурвалжин	6-13
		Нум	8-7
		Нүдтэй дөрвөлжин	9-2
		Дамар	9-4
		Хос иштэй дөрвөлжин	10-1; 10-6
		Чагттай дэгээ	10-3
		Иштэй дөрвөлжин	10-4
3	Нүүрэн талын доод хэсэгт	Сүүлтэй онги бүхий гурвалжин	1-12
		Нүдтэй эвэртэй онги	12-1
4	Баруун талын дунд хэсэгт	Янгир	6-15
5	Ар талын дээд хэсэгт	Янгир	8-9
		Онги	8-10; 8-11
		Иштэй дөрвөлжин	13-1
		Ац	13-2
		Гурвалжин	13-3
		Хэлбэр тодорхойгүй	13-4
6	Ар талын дунд хэсэгт	Дамар	11-1
		Янгир	11-2; 11-5
		Ац	11-3
		Хайруул	11-4
7	Ар талын доод хэсэгт	Онги	6-14

Дээрхээс харахад тамгыг хөшөө чулууны нүүр эсвэл ар талын дунд хэсэгт дүрслэх нь илүү түгээмэл байжээ. Нөгөө талаар хөшөө чулууг босгохоос өмнө аль тамгыг хаана, ямар хэмжээтэй дүрслэхийг тогтсон дэс дараалалтай байсан нь тэдгээрийг нэгэн жигд сийлсэн байдлаас харж болно. Хөшөөний дунд хэсэгт тамга дүрсэлсэн тохиолдол тамгатай хөшөөний ихэнх буюу 11-д нь тааралдаж байна.

Тамгыг гол төлөв нэг эгнээнд дангаар, цөөн тохиолдолд хосолсон байдлаар сийлжээ. Хосолсон байдлаар сийлэхдээ хоёр тамгыг нэг эгнээнд ойр дүрслэхийг илүүтэй эрмэлзэж байсан нь харагдана. Харин цөөн тохиолдолд нэг эгнээнд бус, голлох тамганы баруун дээд эсвэл зүүн доод талд нь дүрсэлсэн тохиолдол байна.

Бүх тамгыг хонхойлгон цохих аргаар сийлжээ. Ингэхдээ харьцангуй нэгэн жигд буюу 0,5-аас 1 см өргөн, 0,2-оос 0,6 см гүн ухаж сийлжээ. Хоёр тохиолдолд л дээрхээс илүү гүн ухаж сийлсэн байх ажээ.

Тамганы байрлал зүй: Тамганы байрлал зүйн хамаарлыг нийт тамгаар бус зөвхөн хөшөө тус бүр дэх гол тамгаар төлөөлүүлэн авч үзэв.

Нэгдүгээр хөшөө: Нүүрэн талдаа 12 тамгатай ба орой хэсэгт дүрслэгдсэн гол тамга нь хөшөө хугарах явцад гэмтэж дүрс нь мэдэгдэхгүй болжээ. Хэдийгээр гол тамганы дүрс танигдахгүй боловч  нь байх хоёр дахь тамга (чагттай саран тамга ) -ыг мөн адил гол тамга хэмээн үзэж болохоор байна. Учир нь энэ тамга хөшөөний орой хэсэгт голлон байрлахаас гадна дунд хэсэгт орших бусад тамганаас байрлалын хувьд илт ялгаатай.

Хоёрдугаар хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 3 тамга байх ба байрлалын хувьд тушаатай, босоо дан саран тамга  нь гол тамга болно.

Гуравдугаар хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 4 тамга байх ба байрлалын хувьд тушаатай, босоо дан саран тамга  нь гол тамга болно.

Дөрөвдүгээр хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 2, ар талын дунд хэсэгт 1 тамгатай. Эдгээрээс  үрэн талын урт сөртөн бүхий иштэй сэрээ тамга  гол тамга болно.

Тавдугаар хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 4 тамга байх ба байрлалын хувьд тушаатай, босоо дан саран тамга  нь гол тамга болно.

Зургаадугаар хөшөө: Нүүр, баруун болон ар талдаа нийт 15 тамгатай. Эдгээрээс нүүрэн талын бичээсийн тээр  болон баруун талд байх бичээсийн дунд  дүрсэлсэн янгир тамга нь гол тамга болно.

Наймдугаар хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 8, ар талын дээд хэсэгт  тамгатай. Эдгээрээс энэхүү хоёр янгир  ,  тамга нь гол тамга болно. Нүүрэн талын дунд хэсэгт 1-р эгнээнд онги тамга байх боловч энэ нь хөшөөний зах хэсэгт,

голлон байрлах янгир тамганаас зайтай байх тул гол тамга хэмээн үзсэнгүй.

Есдүгээр хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 4 тамга байх ба байрлалын хувьд сүйхэн толгойтой янгир тамга  нь гол тамга болно.

Аравдугаар хөшөө: Нүүрэн талын дунд хэсэгт 7 тамга байх ба байрлалын хувьд хос иштэй дөрвөлжин тамга  нь гол тамга болно.

Арван нэгдүгээр хөшөө: Ар талын дунд хэсэгт 5 тамга байх ба байрлалын хувьд дамар тамга  нь гол тамга болно.

Арван хоёрдугаар хөшөө: Нүүрэн талын доод хэсэгт нүдтэй, эвэртэй онги  тамга бий. Хөшөөний орой болон дунд хэсэгт тамга дүрслээгүй ба энэхүү онги нь гол тамга болно.

Арван гуравдугаар хөшөө: Ар талын дээд хэсэгт 4 тамга байх ба байрлалын хувьд иштэй дөрвөлжин тамга  нь гол тамга болно.

Тамганы хувьд гурван хөшөө (№6, 8, 9)-нд янгир, гурван хөшөө (№2, 3, 5)-нд саран тамга, хоёр хөшөө (№10, 13)-нд дөрвөлжин тамга, тус бүр нэгжгээд хөшөө (№1, 4, 11, 12)-нд чагттай сар, сэрээ, дамар, онги тамга голлох ажээ. Эндээс харахад тус дурсгалт газарт болсон үйл явдалд янгир болон саран тамганууд эрх мэдэл, зэрэг зиндааны хувьд арай илүүтэй оролцож байсан хэмээн үзэж болохоор байна.

Тамганы утга агуулга: Нэн эрт цагаас үүсэлтэй тамга тэмдгийн үүсэл гарал, хэрэглээ, хувьсал хөгжлийн талаар дотоод, гадаадын олон эрдэмтэд судалж өөр өөрсдийн санал бодлоо дэвшүүлсэн байдаг (Вайнберг, Новгородова 1976, Яценко 2001, Пэрлээ 1976, Нямаа 2005, Саруулбуян, Даваасамбуу 2008, Самашев и др 2010).

Тамга нь үүсэн буй болсон цагаас хойш нүүдэлчдийн ахуй амьдралд хувийн шинж чанартай эд бараа, гэрийн мал амьтныг таньж ялгахад хэрэглэх тэмдэглэгээ байсан хэдий ч хөгжлийнхөө явцад нэгэн овог бусдаас ялгагдах гол таних тэмдэг нь болжээ. Тамга тус бүр нь ямар нэгэн овгийг илэрхийлэх бөгөөд нэг төрлийн тамганы олон хувилбар нь ойр төрлийн, удам угсаа салаалсан жижиг бүлгүүдийг төлөөлж олон мянганы турш өөрийн үнэ цэнэ, ач холбогдлоо алдалгүй ирсэн байдаг.


Дээрхээс үзэхэд тамга нь үүсэн буй болсон цагаасаа хойш тухайн овог аймаг болон тэдний өмч хөрөнгийг илэрхийлэгч, бусдаас ялгагдах таних тэмдэг төдийгүй эзэмшил газар нутаг болоод түүхэн үйл явдалд оролцогсдыг гэрчлэх баримт болсоор иржээ.

Харьцуулалт ба тайлбар

Тамганы онцлог болон бусад тамгатай харьцуулах нь: Арван хоёр хөшөөний 73 тамга нь 16 төрөл тамганаас бүрдэнэ. Нийт тамганы

дүрслэлд дараах онцлог байна. Тэдгээрийг дурдвал:

Хамгийн олон дүрслэгдсэн нь янгир тамга ажээ. Янгир тамгыг 7 хөшөөнд 16 удаа (5-2, 5-4, 6-1, 6-15, 8-2, 8-3, 8-4, 8-5, 8-6, 8-8, 8-9, 9-1, 9-3, 10-2, 11-2, 11-5) дүрслэсэн ба тэдгээр нь 9 өөр хэлбэртэй байна. Янгир тамгыг нэг хөшөөнд дангаар нь, хоёр болон хамгийн олон нь долоон удаа дүрслэжээ.



Янгир тамга нь эртний Түрэгийн төрийн эрх барих хаад язгууртны Ашина (Эшир) овогт хамаарах ба тухайн үеийн хамгийн тодорхой тамганы нэг юм. Янгир тамгыг руни бичгийн их дурсгалд бичээсийн дээр эсвэл дунд талд сийлэх тогтсон заншил байсан нь Билгэ хаан болон Күлтегиний гэрэлт хөшөө (Самашев и др 2010, 22; 60), Хар балгасын 2-р гэрэлт хөшөө (Болд 2019, 139-140; 261-262)-н дэх дүрслэлээс тодорхой харагддаг. Яг үүнтэй ижил янгир тамганы дүрслэл болон байршил бидний өгүүлэн буй “Донгойн ширээ”-ний руни бичээст 6-р хөшөөнд тохиолдож байна.


Янгир тамгыг гэрэлт хөшөөнөөс гадна тахилын онгоны цогцолбор дурсгал дахь хавтант хашлага, хүн чулуу, чулуун арслан, зэл чулуу болон руни бага бичээсийн хажууд, элдэв хад чулууны гадаргууд олонтоо дүрслэсэн байдаг. Тухайлбал, Шивээт улааны чулуун арслан (Харжаубай 1982, 103-120), Чойрын хүн чулуу (Самашев и др 2010, 26), Гурванмандал (Баяр 1996, 89-102, Зураг.6-2), Хөл Асгат (Radloff 1892, Taf. XV,2), Хангидайн хадны бичээс (Кляшторный 2003, 275-276), Онгийн дурсгал (Малов 1959, 7-11, Рис. 1), Шатар чулууны тахилын хавтан (Самашев и др 2010, 29), Худагтын хүн чулуу (Лхүндэв нар 2015, 116-120), Талын хөшөө (Мөнхтулга нар 2019, 12), Номгон-2 тахилын онгоны зэл чулуу (Энхтөр нар 2022, 75-76), Улаан чулуутын 3-р бичээс (Напил нар 2025, 54-56) зэрэг дурсгалд байна.

“Донгойн ширээ”-ний янгир тамганы нэг онцлог нь 6-аас 9-р хэлбэр -ийн дүрслэл юм. Эдгээр дүрслэлд ижилсэх нэг зүйл нь толгойн хэлбэр болно. Ийм хэлбэртэй тамга ховор боловч Бүрэнгийн Бичигт Улаан хад , Мөрөнгийн Салбар уулын Ханан  (Пэрлээ 1976, 169, хүснэгт-4, зураг-80; 176, хүснэгт-8, зураг-12), Мухарын гэрэлт хөшөөний суурийн яст мэлхийн баруун бөөрөн  (Самашев и др 2010, 27)-д тус тус дүрслэжээ.

Нэг дор янгир тамгыг олноор дүрслэсэн өөр нэг дурсгал бол Өнгөт юм. Тус дурсгалт газрын тахилын онгоны хавтан чулууны ирмэгээр хэд хэдэн төрлийн тамга сийлсэн ба янгир тамганы дүрслэл нь нэлээд өвөрмөц. Энд янгир тамгыг баруун тийш харсан , дөрвөн хөлтэй , эсрэг харсан хос янгир  бүхий байдлаар дүрслэсэн байдаг. Эдгээрээс эсрэг харсан хос янгирын дүрслэл бүхий тамга ховор боловч Бага Газрын чулуу  (Галдан, Жаргалан 2010, 197-209, Зураг. 6-2), Хангай нурууны өмнөд хэсэг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Тайны нурууны өвөр дэх босоо гурван хөшөөтэй тахилын байгууламжийн нэг хөшөөнд  сийлсэн байсныг бид үзсэн билээ. Дурдан буй тамгатай төстэй хос янгир тамга  Билгэ хааны тахилын онгоны зэл чулуу (Батсүх 2004, 162-173) дээр ч байна.

Дээрхээс гадна Бүрэнгийн Бичигт Улаан хад , , , Хутаг -ын түрэг бичээсийн хажууд , , , ,  (Шинэхүү 1976, 36-41), Номгон-2 тахилын онгоны зэл чулуунд , ,  (Энхтөр нар 2022, 75-76) дээрх хувилбараар нэг дор олноор дүрслэгдсэн янгир тамганууд байна.

Тус дурсгалд олноор дүрслэгдсэн өөр нэгэн тамга бол дугуй буюу онги  юм. Онги тамгыг үндсэн, дан болон давхар үүсгэмэл байдлаар 9 хөшөөнд 16 удаа дүрслэжээ. Эдгээрээс үндсэн онги тамгыг 3 хөшөөнд 9 удаа (6-5, 6-7, 6-9, 6-12, 6-14, 8-1, 8-10, 8-11, 10-7) дүрслэсэн бол дан үүсгэмэл байдлаар 2 хөшөөнд 3 удаа (3-2, 6-3, 6-6), давхар үүсгэмэл байдлаар 4 хөшөөнд тус бүр 1 удаа (1-9, 5-3, 6-10, 12-1) дүрслэсэн байна.



Онги тамга түүний маш олон хувилбар Монгол нутаг дахь үе үеийн хадны зураг, хөшөө чулуу, эртний бичээсийн хажууд олонтоо дүрслэгджээ. Энэ нь түүнийг нэн эртнээс улбаатай болохыг илтгэхийн зэрэгцээ эртний овог аймгуудын дунд өргөн тархсан тамга тэмдэг болох нь археологийн болон угсаатны зүйн хэрэглэгдэхүүнээс тодорхой харагддаг. Дээрх хэрэглэгдэхүүнээс гадна эзэнт гүрний үеийн Монгол хаадын дэлдүүлсэн зоосон мөнгө (Нямаа 2005, 36-40; 49-51; 121-122), Монгол угсаатны малын тамганы хэлбэрээр хадгалагдан (Пэрлээ 1976, 22; 138; 164; 187) өнөө цагт ч хэрэглэгдсээр байна.

“Донгойн ширээ”-ний онги тамгатай ижилсэх Түрэг, Уйгурын үед хамаарах тамга бүхий

дурсгалт газар хэд хэд байна. Тэдгээр нь Шивээт улаан (Харжаубай 1982, 106), Бүрэнгийн Бичигт улаан хад, Бигэрийн Хар аараг, Баянжаргалангийн Мөрт (Пэрлээ 1976, 177, хүснэгт-4, зураг-80), Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгой (Шинэхүү 1972, 143), Гурванмандал (Баяр 1996, 92), Чандманы Шаахар толгой (Цэвээндорж, Батболд 2008, 124), Бор-Өндөрийн Талын хөшөө (Мөнхтулга нар 2019, 10-12) зэрэг болно. Дээрх дурсгалт газруудад онги тамгыг олон хувилбараар дүрсэлсэн ба зарим нь руни бичээсийн хамт байх ажээ.

Олон хувилбараар дүрслэгдсэн дээрх хоёр тамганаас гадна Түрэг, Уйгурын үеийн нийтлэг тамганууд болох гурвалжин тамга (1-5, 1-12, 2-2, 2-3, 6-2, 6-13, 13-3) , саран тамга (1-2, 2-1, 3-1, 5-1, 6-4) , сэрээ тамга (1-3, 1-4, 1-11, 4-1) , хайруул тамга (1-8, 6-11, 11-4) , ац тамга (1-10, 11-3, 13-2) , дармар тамга (9-4, 11-1) , дэгээ тамга (4-2, 10-3) , чагтан тамга (1-3) , зуузаг (могой?) тамга (1-7) , эвэртэй угалз тамга (3-4) , нуман тамга (8-7)  зэргийг тус тус дүрсэлжээ.

Эдгээрээс ацтай сэрээ тамга -тай ижил тамга Гурванмандал уулын Өмнөд Мандалын хаданд байхаас гадна Дунд болон Хойд Мандалын хаданд ,  хэлбэрийн сэрээ тамга (Баяр 1996, 89-102, Зураг. 5, 6) хэд хэд байна. Ацтай сэрээ тамгатай тун төстэй тамга Шаахар толгойн хадны зураг -т ийм хэлбэртэй байна (Цэвээндорж, Батболд 2008, 49-51. хавсралт-I, зураг 3-10). Шаахар толгойн хадны зураг дахь тамга тэмдгийн холбогдох он цагийг тодорхой дурдаагүй боловч энэхүү тамгыг бид эртний Түрэгийн үед холбогдох боломжтой хэмээн үзэв. Учир нь ийм тамга эртний Түрэг, Уйгурын тамганы дурсгалд олонтоо тохиолдохоос гадна Шаахар толгойд эртний Түрэг бичгийн дурсгал байгаа нь уг тамгыг Түрэг болохыг илтгэнэ. Мөн тус дурсгалт газарт Түрэгийн үел хамаарч болох сэрээ тамганы бусад хэлбэр  (Бямбасүрэн 2010, 216) ч байна.

Дамар  тамганы ижил төстэй хувилбарууд Шаахар толгой ,  (Цэвээндорж, Батболд 2008, 49-51. хавсралт- II, зураг 18. 6, 7), Өмнөд Мандал ,  (Баяр 1996, 89-102, зураг 5), Бага Ойгор ,  (Jacobson et al 2001, 389, 468. зураг. 997, 1282, 1283) зэрэг газарт хэд хэдэн янзаар дүрсэлсэн байх ажээ. Мөн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хөх хадны тахилын онгоны хөшөө чулуунд  (Бямбасүрэн 2010, 216), Баян-

Өлгий аймгийн Эрээн харганатын бичээсийн хажууд  (Өмирбек 2015. 283), Хөрөөгийн үзүүр , Тайхар чулуу -нд (Гантулга нар 2015, 266) дүрсэлсэн тохиолдол ч байна.

Эртний Түрэг тамганы дунд түгээмэл байх өөр нэг тамга бол ац (булан) юм. Шаахар толгойн хадны зурагт энэ тамгыг үндсэн  болон давхар үүсгэмэл ,  байдлаар (Цэвээндорж, Батболд 2008% 49-51. хавсралт- II, зураг 18. 9, 10, 12), Гурван мандалын хадны зурагт үндсэн  дан үүсгэмэл , , , давхар үүсгэмэл , , ,  (Баяр 1996, 89-102, зураг. 5, 6, 7) байдлаар, Ховдын Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгойн руни бичээсийн хажууд , ,  (Шинэхүү 1972, 143) тус тус хувилбараар дүрсэлжээ.

Угалз тамга  нь ихэнхдээ руни бичээсийн ойролцоо дүрслэгдсэн байх ажээ. Тухайлбал, бидний өгүүлэн буй тамгатай ижил төстэй тамга  Байшинт хар вуул (Osawa et al 2020, 100-102), Цагаан салаа  (Jacobson et al 2001, 224. зураг. 350)-д руни бичээсийн хажууд байх бол Бага Газрын чулуу  (Галдан, Жаргалан 2010, 197-209, Зураг. 6-5)-нд ч бас байна. Дээрх тамгатай хэлбэр, дүрслэлийн хувьд ижил төстэй тамгыг өнөөгийн торгуудууд хахууль (дэгээ), захчингууд угалз тамга хэмээн нэрлэдэг ажээ.

Харин Түрэг, Уйгурын үеийн тамгануудад харьцангуй цөөн тохиолддог дөрвөлжин , , , , , , ,  тамга, түүний хэд хэдэн хувилбар Донгойн ширээний тамганы дунд байна. Эдгээрээс нүдтэй дөрвөлжин тамга нь Бичигт улаан хад , Өнгөт  зэрэг дурсгалд энэхүү хувилбараар тохиолдож байна.

”Донгойн ширээ”- ний тамганы дунд  ховор, содон хоёр тамга байгаа нь хайч (3-3)  болон хямсаа (4-3)  тамга юм. Хэлбэрийн хувьд багаж хэрэгслийн дүрст тамга бөгөөд харьцуулах бусад баримт сэлт Түрэг, Уйгурын үеийн тамганы дунд одоогоор алга байна. Хойшдын тамга судлалаар энэхүү хоёр тамганы нууцлаг байдал нь нээгдэх буй за.

Ямартай ч дээрх баримт, эх хэрэглэгдэхүүн нь өнөөгийн Монгол орны зүүн өмнөд нутагт тэртээ VIII зууны эхэн хагаст олон овог аймаг хуран цуглаж, сүрлэг өндөр хөшөө чулуут тахилын цогцолбор цогцлоон босгож өөр өөрсдийн овгийн

тамгаа сийлж үлдээсэн томоохон тэмдэглэлт үйл явдлын гэрч болж байна.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд “Донгойн ширээ”-ний дурсгал дахь тамганы дүрслэл болон бүтцийн онцлогийг судалж, байрлал зүй, утга агуулга, түүхэн ач холбогдлыг тодруулахыг зорив. Судалгаанд хээрийн малтлагын явцад орж илрүүлсэн хөшөө чулуунд сийлсэн эх хэрэглэгдэхүүн болох тамганы дүрслэл, хэмжилт, бусад эх сурвалжуудыг ашиглан дүрслэл болон бүтэц судлалын аргуудыг хослон хэрэглэснээр тамганы хэлбэр, байрлал зүйн зохион байгуулалт, утга зүйн уялдаа холбоог илүү нарийвчлан шинжлэх боломж бүрдсэн юм.

Дүрслэлийн шинжилгээний үр дүнд тамганы олон хэлбэрийн үндсэн дүрс болон нэмэлт дүрс (үндсэн, дан болон давхар үүсгэмэл)-үүд нь санамсаргүй бус, тодорхой бэлгэдэл, утга санааг илэрхийлсэн зохион байгуулалттай болох нь тогтоогдлоо. Тамганы дүрслэл нь овог аймаг, тэдний нийгэмд эзлэх байр суурь, эрх мэдэл, нутаг дэвсгэр, соёлын үнэт зүйлсийг илтгэх таних тэмдэг болж байсныг харуулж байна. Харин бүтцийн шинжилгээгээр тамганы хэлбэр дүрс, хэмжээ, хоорондын харьцаа, байрлал зүй зэрэг нь тухайн үеийн овог аймгуудын зан үйлийн уламжлал, гоо зүй хэм хэмжээний ойлголт, дархчуудын чулууны сонголт, технологийн боломж зэрэгтэй нягт холбоотой болохыг тогтоов.

Тамганы онцлогийн тухай харьцуулсан судалгаагаар “Донгойн ширээ”-ний дурсгал дахь тамганууд нь хөрш зэргэлдээх нүүдэлчин овог аймгуудын соёлын ижил төстэй дурсгалтай нийтлэг шинжийг хадгалж байгаа боловч оршин буй газар нутгийн онцлог, цаг хугацаа, түүхэн үйл явдал зэргээс шалтгаалсан ялгаатай хэв маяг, утга агуулгатай байна хэмээн үзэв. Энэ нь тамгыг зөвхөн дүрс тэмдэг бус, тухайн үеийн нийгэм улс төр, соёл, үзэл санааны цогц илэрхийлэл болохыг нотолж байна.

Цаашид илүү олон дурсгалыг хамруулсан харьцуулсан судалгаа хийж тамга бүрийн эзэн холбогдогч овог аймгийг тогтоож, тамганы хөгжил, хувьслыг тодруулах нь нэн чухал байна.

Талархал

“Донгойн ширээ”-ний дурсгалыг Монгол-Японы хамтарсан төслийн хүрээнд 2015-2017 онд малтан судлах хээрийн судалгааны ажилд оролцон ажилласан нийт оюутан, жолооч болон эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Б.Батдалай, магистр Г.Ангарагдөлгөөн нарт талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

Батсүх, Д. Билгэ хааны тахилын онгоны балбал чулууны тамга. // *Археологийн судлал*. Tomus XXII, fasc.14. Улаанбаатар, 2004: 162-173.

Баяр, Д. Гурван Мандалын хадны зураг. // *Археологийн судлал*. Tomus XVI, fasc.7. Улаанбаатар, 1996: 89-102.

Болд, Л. *Орхон бичгийн дурсгал VI*. Улаанбаатар, 2019.

Бямбасүрэн, Х. 2008 онд Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт явуулсан түүх соёлын дурсгалт газар, үл хөдлөх дурсгалыг бүртгэх ажлын эхний үр дүнгээс. // *Түүхийн товчоон*. Tom V. fasc.14. Улаанбаатар, 2010: 206-217.

Вайнберг, Б.И., Новгородова, Э.А. Заметки о знаках и тамгах Монголии. // *История и культура народов Средней Азии (древность и средние века)*. Москва, 1976.

Галдан, Г., Жаргалан, Б. Бага Газрын Чулууны хадны зураг дахь тамга тэмдгийн дүрслэл. // *Археологийн судлал*. Tomus (IX) XXIX, fasc.10. Улаанбаатар, 2010: 174-185.

Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай, Ж. Хойд Тамирын хөндий дэх эртний тамга тэмдгүүд. // *Археологийн судлал*. Tomus XXXV, fasc.17. Улаанбаатар, 2015: 249-273.

Кляшторный, С.Г. *История центральной Азии и памятники рунического письма*. Санкт-Петербург, 2003.

Jacobson, E., Kubarev, V., Tseveendorj, D. *Repertoire des petroglyphes d'asie centrale. Fascicule № 6: Mongolie du nord-ouest Tsagaan Salaa / Baga Oigor*. Paris, 2001.

Лхүндэв, Г., Ангарагдөлгөөн, Г., Осава, Т., Сайто, Ш. Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ажлын үр дүнгээс. // *Монголын археологи-2014. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2014 оны хээрийн судалгааны үр дүн*. Улаанбаатар, 2015: 116-120.

Малов, С.Е. *Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии*. Москва-Ленинград, 1959.

Мөнхтулга, Р., Оосава, Т. Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анх удаа уншсан нь // *Эртний Түрэгийн түүх, соёл (Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)*. МУИС-ийн Ази судлалын тэнхим. Түрэг судлалын салбар. Улаанбаатар, 2015: 21-55.

Мөнхтулга, Р., Бүрэнтогс, Г., Арьяажав, Б. *Талын хөшөөний тахилын онгон*. Улаанбаатар, 2019.

Мөнхтулга, Р., Болорбат, Ц., Энхтөр, А., Буянхишиг, Ц. *Донгойн ширээн дурсгалыг малтан судалсан нь*. Улаанбаатар, 2014.

Напил, Б., Энхтөр, А., Төрбат, Р. Улаан чулуутын эртний түрэг бичээсийн угсаатан-соёлын утга зүйн тухайд. // *Археологийн судлал*. Tomus XLVIII, fasc.5. Улаанбаатар, 2025: 52-57.

Нямаа, Б. *Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын овгийн тамга (XIII-XIV)*. Улаанбаатар, 2005.

Osawa, T., Lkhundev, G., Batzorig, O., Batdalai, B. Newly discovered runic inscription and tamga-seals from Baishint Khar Mountain. // *Археологийн судлал*. Tomus XXXIX, fasc.8. Улаанбаатар, 2020: 98-104.

Өмирбек, Б. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дэх тамга тэмдгийн дүрслэлүүд. // *Археологийн судлал*. Tomus XXXV, fasc.18. Улаанбаатар, 2015: 274-286.

Пэрлээ, Х. *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. Улаанбаатар, 1976.

Самашев, З., Базылхан, Н., Самашев, С. *Древнетюрские тамги*. Алматы, 2010.

Саруулбуян, Ж., Даваасамбуу, А. *Монгол адууны тамганы ойлгог*. Улаанбаатар, 2008.

Түмэн, Д., Эрдэнэ, М., Хатанбаатар, Д., Анхсанаа, Г., Ванчигдаш, Ч. “Дорнод Монгол” төслийн хүрээнд гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа (2010). // *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 6, No.1 (365) December. Улаанбаатар, 2010: 167-215.

Харжаубай, С. Шивээт улааны цогцолбор дурсгалын тухай дахин өгүүлэх нь. // *Studia Archaeologica*. Tomus X, fasc.7. Улаанбаатар, 1982: 103-116.

Цогтбаатар, Б., Осава, Т., Сайто, Ш., Эрдэнэ-Очир, Н., Лхүндэв, Г., Буянхишиг, Ц., Батдалай, Б., Амарболд, Э., Ангарагдөлгөөн, Г., Ганбаатар, Л. *Монгол-Японы хамтарсан «Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа» төслийн 2015 оны хээрийн шинжилгээний ангийн тайлан (2-р хэсэг)*. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар, 2016.

Цогтбаатар, Б., Эрдэнэ-Очир, Н., Лхүндэв, Г., Батдалай, Б., Амарболд, Э., Ангарагдөлгөөн, Г., Дэлгэрмаа, Л., Осава, Т., Сайто, Ш. *Монгол-Японы хамтарсан «Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа» төсөл: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг “Донгойн ширээ”-н дурсгалт газар 2016 онд хийсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан*. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар, 2017.

Цогтбаатар, Б., Эрдэнэ-Очир, Н., Осава, Т., Лхүндэв, Г., Сайто, Ш., Батдалай, Б., Амарболд, Э., Ангарагдөлгөөн, Г. “Донгойн ширээ”-ний дурсгалын археологийн судалгаа. (<<Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх,

археологийн судалгаа>> төслийн 2015-2016 оны малтлага судалгааны үр дүн). Улаанбаатар, 2017.

Цэвээндорж, Д., Батболд, Н. *Шаахар толгойн хадны зураг*. Улаанбаатар, 2008.

Radloff W. *Atlas der Alterthümer der Mongolei. Arbeiten der Orchon-Expedition*, 1. Lieferung. St-Peterburg, 1892.

Шинэхүү, М. Даривын эртний түрэг бичээс. // *Монголын эртний түүх-соёлын зарим асуудал*. Tom V. fasc. 10. Улаанбаатар, 1972: 135-147.

Шинэхүү, М. Хутаг уулын түрэг бичээс. // *ШУАМ*. №4. Улаанбаатар, 1976: 36-41,

Энхтөр, А., Дархан, К., Напил, Б., Нурболат, Б., Буянхишиг, Ц., Батболд, Г., Далантай, С. Кутлуг хааны тахилын онгон цогцолбор, гэрэлт хөшөө. // *Археологийн судлал*. Tomus XLI, fasc.7. Улаанбаатар, 2022: 69-86.

Яценко, С.А. *Знаки-тамги ираноязычных народов древности и раннего средневековья*. Москва, 2001.

REFERENCES

Batsukh, D. 2004. Bilge khaany takhiliin ongony balbal chuluuny tamga. // *Arkheologiin sudlal* 22 (14): 162-173. Ulaanbaatar.

Bayar, D. 1996. Gurvan Mandalyn khadny zurag. // *Arkheologiin sudlal* 16 (7): 89-102. Ulaanbaatar.

Bold, L. 2019. *Orkhon bichgiin dursgal VI*. Ulaanbaatar.

Byambasuren, Kh. 2010. 2008 ond Khovd aimgiin Erdenebüren sumyn nutagt yavuulsan tüükh soyolyn dursgalt gazar, ül khödlökh dursgalyg бүртгэх ажлын екhnii үр дүнgees. *Tüühiin товchoon* 5 (14): 206-217. Ulaanbaatar.

Vainberg, B. I., and E. A. Novgorodova. 1976. Zametki o znakhakh i tamgakh Mongolii. // *Istoriia i kul'tura narodov Srednei Azii (drevnost' i srednie veka)*. Moscow.

Galdan, G., and B. Jargalan. 2010. “Baga Gazryn Chuluuny khadny zurag dakhi tamga temdgiin дүрслел.” *Arkheologiin Sudlal* 29 (10): 174-185. Ulaanbaatar.

Gantulga, J., Ch. Yerööl-Erdene, and J. Magai. 2015. “Khoid Tamiryn khöndii dekh ertnii tamga temdgiid.” *Arkheologiin Sudlal* 35 (17): 249-273. Ulaanbaatar.

Klyashtorny, S. G. 2003. *Istoriia tsentral'noi Azii i pamiatniki runeskogo pis'ma*. Saint Petersburg.

Jacobson, Esther, Vladimir Kubarev, and D. Tseveendorj. 2001. *Répertoire des pétroglyphes d'Asie centrale. Fascicule 6: Mongolie du nord-ouest, Tsagaan Salaa / Baga Oigor*. Paris.

Lkhundev, G., G. Angaragdulguun, T. Osawa, and Sh. Saitō. 2015. Mongol-Yapony khamtarsan “Dornod Mongolyn ertnii Türegiin üyeiin tüükh,

arkheologiiin sudalgaa” tösliin kheerlin shinjilgeenii ajlyn ür dūngees.” // *Mongolyn Arkheologi-2014: ShUA-iin Arkheologiiin khūreelengiiin 2014 ony kheerlin sudalgaany ür dūn*, 116-120. Ulaanbaatar.

Malov, S. E. 1959. *Pamiatniki Drevnetiurkskoi Pis'mennosti Mongolii i Kirgizii*. Moscow–Leningrad.

Munkhtulga, R., and T. Osawa. 2015. “Dongoin shireen dursgalyn gerelt khōshōōnii bicheesiig ankh udāa unshsan ni.” // *Ertanii Tūregiin tūūkh, soyol (Olon ulsyn erdem shinjilgeenii khurlyn emkhetgel)*, 21-55. Ulaanbaatar: MUIS, Department of Asian Studies, Turkology Section.

Munkhtulga, R., G. Burentugs, and B. Aryaajav. 2019. *Talyn khōshōōnii takhilyn ongon*. Ulaanbaatar.

Munkhtulga, R., Ts. Bolorbat, A. Enkhtur, and Ts. Buyankhishig. 2014. *Dongoin shireen dursgalyn maltan sudalsan ni*. Ulaanbaatar.

Napil, B., A. Enkhtur, and R. Turbat. 2025. Ulaan chuluutyn ertnii tūreg bicheesiin ugsaatan–soyoliin utga zūin tuhaid. // *Arkheologiiin Sudlal* 48 (5): 52-57. Ulaanbaatar.

Nyamaa, B. 2005. *Mongolyn ezēnt gūrnii zooson mūngū ba khaadyn ovgiin tamga (XIII–XIV)*. Ulaanbaatar.

Osawa, T., G. Lkhundev, O. Batzorig, and B. Batdalai. 2020. Newly discovered runic inscription and tamga-seals from Baishint Khar Mountain. // *Arkheologiiin Sudlal* 39 (8): 98-104. Ulaanbaatar.

Ömirbek, B. 2015. Bayan-Ulgii aimgiin nutag devsgar dekh tamga temdgiin dūrslelūūd. // *Arkheologiiin Sudlal* 35 (18): 274-286. Ulaanbaatar.

Perlee, Kh. 1976. *Mongol tūmnii garlyg tamgaar khaij sudlakh ni*. Ulaanbaatar.

Samashev, Z., N. Bazytkhan, and S. Samashev. 2010. *Drevnetyurskie tamgi*. Almaty.

Saruulbuyan, J., and A. Davaasambuu. 2008. *Mongol aduuny tamgany oillogo*. Ulaanbaatar.

Tumen, D., M. Erdene, D. Khatanbaatar, G. Ankhsanaa, and Ch. Vanchigdash. “Dornod Mongol” tōlsiin khūreend gūitsetgesen arkheologiiin kheerlin sudalgaa (2010). // *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology* 6, no. 1 (365) (December): 167-215. Ulaanbaatar.

Kharjaubai, S. 1982. Shiveet Ulaany tsogtsolbor dursgalyn tukhai dakhin ōgūlekh ni. // *Studia Archaeologica* 10 (7): 103-116. Ulaanbaatar.

Tsogtbaatar, B., T. Osawa, S. Saito, N. Erdene-Ochir, G. Lkhundev, Ts. Buyankhishig, B. Batdalai, E. Amarbold, G. Angaragdulguun, and L. Ganbaatar. 2016. *Mongol–Yapony khamtarsan “Dornod Mongolyn ertnii Tūregiin üeiin tūūkh, arkheologiiin*

sudalgaa” tōsliin 2015 ony kheerlin shinjilgeenii angiiin tailan (2-r kheseg). ShUA-iin Arkheologiiin Khūreelengiiin GBSKh, Ulaanbaatar.

Tsogtbaatar, B., N. Erdene-Ochir, G. Lkhundev, B. Batdalai, E. Amarbold, G. Angaragdulguun, L. Delgermaa, T. Osawa, and Sh. Saitō. 2017. *Mongol–Yapony khamtarsan “Dornod Mongolyn ertnii Tūregiin üeiin tūūkh, arkheologiiin sudalgaa” tōsöl: Sūkhbaatar aimgiin Tūvshinshiree sumyn nutag “Dongoin Shiree”-n dursgalt gazar 2016 ond khiisen arkheologiiin maltaga sudalgaany ajlyn tailan*. ShUA-iin Arkheologiiin Khūreelengiiin GBSKh, Ulaanbaatar.

Tsogtbaatar, B., N. Erdene-Ochir, T. Osawa, G. Lkhundev, Sh. Saitō, B. Batdalai, E. Amarbold, and G. Angaragdulguun. 2017. “Dongoin Shiree”-nii dursgalyn arkheologiiin sudalgaa (Dornod Mongolyn ertnii Tūregiin üeiin tūūkh, arkheologiiin sudalgaa tōsliin 2015–2016 ony maltaga sudalgaany ür dūn). Ulaanbaatar.

Tseveendorj, D., and N. Batbold. 2008. *Shaakhar tolgoin khadny zurag*. Ulaanbaatar.

Radloff, W. 1892. *Atlas der Alterthümer der Mongolei. Arbeiten der Orchon-Expedition, 1. Lieferung*. St. Petersburg.

Shinekhue, M. 1972. Darivyn ertnii tūreg bichees. // *Mongolyn ertnii tūūkh-soyolyn zarim asuudal* 5, (10): 135-147. Ulaanbaatar.

Shinekhue, M. 1976. Khutag uulyn tūreg bichees. // *ShUAM* (4). 36-41. Ulaanbaatar.

Enkhtur, A., K. Darkhan, B. Napil, B. Nurbulat, Ts. Buyankhishig, G. Batbold, and S. Dalantai. 2022. Kutlug khaany takhilyn ongon tsogtsolbor, gerelt khōshōō. *Arkheologiiin Sudlal* 41 (7): 69-86. Ulaanbaatar.

Yatsenko, S. A. 2001. *Znaki-tamgi iranoiazыchnykh narodov drevnosti i rannego srednevekovia*. Moscow.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>